



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 26 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэр, Улсын онцгой комиссын 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улс, хот хоорондын зорчигч тээвэр, суудлын галт тэрэг болон орон нутгийн хуваарьт нислэг, хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас 3 дугаар сарын 3-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгаж, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал С.Баатаржав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Монгол Улс, БНСУ хоорондын 2 талын хуваарьт нислэгийг түр зогсоосон хугацааг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 11-ний өдрийг дуустал сунгах (14 хоног), Монгол Улс, Япон Улс хоорондын 2 талын хуваарьт нислэгийг 2 дугаар сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 11-ний өдрийг дуустал түр зогсоохыг (13 хоног) Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд даалгасугай.

3. БНСУ, Япон, Итали Улсад сүүлийн 14 хоног зорчсон гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, эдгээр улсаас эх орондоо буцаж ирэх Монгол Улсын иргэдийг улсын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд түр тусгаарлан, шаардлагатай зардлыг тухайн иргэн, хуулийн этгээдээс гаргуулах арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасугай.

4. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын нэмэлт нөөц бүрдүүлэх, шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай.

5. Коронавируст халдварын тархалтын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, хүрэлцээг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэлт, хүнсний стратегийн бүтээгдэхүүний экспортыг хязгаарлах, хангамжийн сүлжээ, худалдааны төв, дэлгүүрийн үйл ажиллагааг хяналтад авах, хангамж, үлдэгдлийн судалгаанд үндэслэн зохицуулалт хийх, борлуулалтын хуваарь гаргах, худалдан авагч, иргэдэд өдөрт борлуулах хэмжээг тогтоох, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсэх, дамлан худалдаалахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Онцгой байдлын

ерөнхий газрын дарга хошууч генерал Т.Бадрал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчдыг гадаад орон руу албан томилолтоор зорчихыг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд зогсоох арга хэмжээ авахыг яам, агентлаг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.


7. Төрийн албан хаагч болон гадаадын иргэд албан ажлын зайлшгүй шаардлагаар гадаад оронд зорчих болон Монгол Улсад нэвтрэх тохиолдолд Улсын онцгой комиссын даргын зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт даалгасугай.

8. Коронавируст халдварын талаарх худал, ташаа мэдээллийг цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр санаатай болон санамсаргүйгээр түгээсэн, өвчний голомт бүртгэгдсэн улсаас ирсэн бөгөөд аяллын түүх болон биеийн эрүүл мэндийн байдлаа хуурамчаар мэдүүлсэн, мэдээлэл өгөхөөс татгалзсан, төрийн болон мэргэжлийн байгууллагын шийдвэр, хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, буруутай этгээдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлах арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал С.Баатаржав, Тагнуулын ерөнхий газрын дарга, бригадын генерал Д.Гэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

9. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд шуурхай зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулах, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, аймаг, нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах тухай мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай хүргэх, сурталчлах, мэдээллийн урсгалын нэгдмэл байдлыг хангах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Ц.Ганзоригт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН